

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН  
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

## АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
3.1	Бараа материалын данстай холбоотой асуудал	11
3.1.1	Илрүүлэлт	11
3.1.2	Эрсдэл	11
3.1.3	Өгсөн зөвлөмж	11
3.1.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	11
3.2	Хангамжийн бараа материалын данстай холбоотой асуудал	12
3.2.1	Илрүүлэлт	12
3.2.2	Эрсдэл	12
3.2.3	Өгсөн зөвлөмж	12
3.2.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	12
3.3	Дотоод хяналттай холбоотой асуудал	12
3.3.1	Илрүүлэлт	12
3.3.2	Эрсдэл	12
3.3.3	Өгсөн зөвлөмж	12
3.3.4	Байгууллагаас өгсөн хариу, тайлбар	12
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	14
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	16
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	18
4.4	Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	20
4.5	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6	Зөрчлийн нэгтгэл	

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

2019.02.22 № 06/210  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

\\10.10.10\Bichig\_Khereg\Yawsan\_Bichig\2019\0222SAG8.Docx

070450

### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. АУДИТЫН ТАЙЛАН

### ОРШИЛ

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Монгол Солонгосын Политехник Коллежийн захирал Х.Цэгмид танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 20-ноос 2019 оны 02 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Баян суварга Аудит” ХХК-ийн аудитор Х.Тунгалагтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр 25-ны өдрийн 1/42 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Монгол Солонгосын Политехник Коллежийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

#### **Эрхэм зорилго:**

Монгол Солонгосын Политехник Коллеж нь “Дэлхийн хөгжлийн ерөнхий хандлага, Монгол орны эдийн засаг, нийгмийн хэрэгцээ шаардлагыг хангах, зах зээлийн эдийн засгийн харилцаанд өрсөлдөх, хөрвөх чадвар бүхий хүмүүнлэг ардчилсан нийгмийн харилцаанд төлөвшсөн мэргэжилтэн бэлтгэх, нийгмийн үйлчилгээний орчин бүрдүүлж иргэдэд үйлчлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

#### **Үйл ажиллагааны чиглэл:**

Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын 2012 оны 19 дүгээр тушаалаар Монгол Солонгосын Политехник Коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэжил эзэмшүүлэх, техникийн боловсрол олгох сургалтын үйл ажиллагаа явуулах,
- Захиалгат болон насанд хүрэгчдэд мэргэжил олгох сургалт

Монгол Солонгосын Политехник Коллежийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Монгол Солонгосын Политехник Коллежийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын

Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хууль
- Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам */Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан А/198/215 дугаар тушаалаар баталсан/*
- “Мэргэжлийн болон техник боловсролын сургалтын байгууллагын бүтэц орон тоо батлах тухай” Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/21 дүгээр тушаал.

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт хийгдээгүй байна.

#### **НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Монгол Солонгосын Политехник Коллежийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Монгол Солонгосын Политехник Коллеж санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Монгол Солонгосын Политехник Коллежийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

#### **ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Аудитын явцад Монгол Солонгосын Политехник Коллежийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг

судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 13 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 4 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

#### **МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд 2018 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын суурь үзүүлэлтийг сонгов.

Төсвийн байгууллагын хувьд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг нийт зардлаар тооцоолж авч үзэх нь зохимжтой гэж үзсэн болно.

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны нийт зардал 3,404,859.1 мянган төгрөг бөгөөд түүний 2 хувь болох 69,097.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

#### **АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 8 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 7 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.



Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал

/мянган төгрөгөөр/

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	3	13,481.1	
Дүн		3	13,481.1	

Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зөвлөмж өгөх асуудлыг менежментийн захидалд оруулж өгсөн бөгөөд аудитаар бусад хэлбэрээр шийдэх алдаа, зөрчилтэй асуудал илрээгүй болно.

#### **ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ БУЮУ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ**

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлын төлөвлөлт, гүйцэтгэл, норм нормативын хэрэгжилтийг шалгах.

#### **ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Монгол Солонгосын Политехник Коллежийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 57 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 2,298,188.1 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 2,270,150.4 мянган төгрөг буюу 98.8 хувьтай тайлагнагдсан байна.

Тус коллежийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогын төлөвлөгөө 68,000.0 мянган төгрөг байхаар төсөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 127,225.4 мянган төгрөгийн орлого орж, 187.1 хувийн биелэлттэй тайлагнасан. Энэ нь орлогын төлөвлөгөө үндэслэл муутай хийгдэж байгаатай холбоотой байна.

#### **Шилэн дансны мэдээлэл**

Монгол Солонгосын Политехник Коллежийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж үзэхэд шилэн дансны сайтад нийт 9 төрлийн 49 мэдээлэл оруулахаас 47-г оруулсан, үүнээс 10 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож оруулсан, мөн тухайн тайлант жилийн

санхүүгийн тайлан, санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт гэсэн 2 мэдээллийг оруулаагүй байна.

#### **Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж, 1 албан шаардлага өгсөн. Зөвлөмж, албан шаардлагын биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

#### **Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Монгол Солонгосын Политехник Коллежийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **БАРАА МАТЕРИАЛЫН ДАНСТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ**

##### **1. Илрүүлэлт:**

Тус коллежийн шатахууны зарцуулалтын тайлан тооцоог шалгаж үзэхэд 2018 онд нийт 4,100.0 мянган төгрөгийн шатахууны талоныг жолоочийн тооцооны хуудас хөтлүүлээгүй, шаардах хуудсаар олгож, зардалд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д “анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй байна.

##### **2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах, хууль эрхийн акт зөрчигдөх.

##### **3. Өгсөн зөвлөмж:**

Цаашид Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтыг баримтлан ажиллаж, жолоочийн тооцооны хуудсыг хөтлүүлэн шатахууны зарцуулалтад бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах.

##### **4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

### **3.2 Хангамжийн бараа материалын данстай холбоотой асуудал**

#### **1. Илрүүлэлт:**

Тус коллежийн 2018 онд батлагдсан төсвийг бүлгийн дүнгээр хянаж шалгахад хангамжийн бараа материалын зардлыг батлагдсан төсвөөс 9,381.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-д “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасныг зөрчсөн байна.

#### **2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт суларч, хууль эрхийн акт зөрчигдөх.

#### **3. Өгсөн зөвлөмж:**

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дугаар заалтыг хэрэгжүүлж, төсвийг зохистой удирдаж, дотоод хяналтыг сайжруулах.

#### **4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

### **3.3 Дотоод хяналттай холбоотой асуудал**

#### **1. Илрүүлэлт:**

Тус коллежийн Хяналт-шинжилгээ, дотоод аудитын ажилтан 2018 оны 3 дугаар сард шинээр томилогдож, төлөвлөгөөний дагуу 9 чиглэлээр хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд хийх дотоод хяналтыг зөвхөн аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг шалгаж хангуулахад чиглүүлж ажилласан байна.

Энэ нь Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-ийн 5 дугаар зүйлд заасан “Үйл ажиллагааны үндсэн чиглэл”-тэй нийцэхгүй байна.

#### **2. Эрсдэл:**

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд холбогдох хууль эрхийн актууд зөрчигдөх, хэрэгжихгүй байх, санхүүгийн сахилга, хариуцлага сулрах.

#### **3. Өгсөн зөвлөмж:**

Хяналт-шинжилгээ, дотоод аудитын 2019 оны жилийн ажлын төлөвлөгөөнд санхүүгийн анхан шатны бүртгэлийн хөтлөлт, өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт, төсвийн зарцуулалт, тайлан тооцоонд дотоод хяналт хийх, санхүүгийн сахилга хариуцлагыг сайжруулах асуудлыг тусган хэрэгжүүлэх.

#### **4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийн дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэнэ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 06 дугаар сарын 25-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>783,157,922.27</u></b>	<b><u>557,505,589.29</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	-	-
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	-	-
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	-	-
<b>3122</b>	<b>Гадаад валют</b>	-	-
<b>32</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ</b>	-	-
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	18,739,558.04	-
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,986,558.04	
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	14,753,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	14,753,000.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага		
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	764,418,364.23	557,505,589.29
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	627,135,699.60	423,599,922.50
35110	Тусгай зориулалттай материал	627,043,742.00	423,011,552.50
35130	Эм боох материал	91,957.60	588,370.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	137,282,664.63	133,905,666.79
35410	Бичиг хэргийн материал	3,943,605.00	7,936,965.00
35420	Аж ахуйн материал	128,729,709.63	124,863,701.79
35430	Сэлбэг хэрэгсэл	368,700.00	365,000.00
35440	Түлш, шатах тослох материал	150,000.00	
35450	Барилгын засварын материал	4,090,650.00	740,000.00
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал		
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10,056,817,689.54</u></b>	<b><u>13,926,340,918.97</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	10,056,817,689.54	13,926,340,918.97
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	10,054,434,355.98	13,323,685,552.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,626,584,158.00	10,764,448,987.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	1,692,013,345.90	174,438,738.25
39203	Авто-тээврийн хэрэгсэл	224,836,881.86	224,836,881.86
39204	Хуримтлагдсан элэгдэл	70,870,139.04	98,173,835.64
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,137,323,189.28	4,068,433,725.59
39206	Хуримтлагдсан элэгдэл	1,787,949,368.22	2,288,845,489.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	872,048,900.09	842,408,406.79
39208	Хуримтлагдсан элэгдэл	302,353,388.63	370,539,269.67
39209	Зам, гүүрийн байгууламж	116,759,000.00	304,667,000.86
39210	Хуримтлагдсан элэгдэл	114,522,040.16	
39214	Бусад үндсэн хөрөнгө	1,590,668.28	1,590,668.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	1,590,668.28	1,590,668.28
39216	Дуусаагүй барилга, байгууламж		
39217	Ном	44,590,508.70	50,887,883.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	2,383,333.56	602,655,366.93

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

39301	Програм хангамж	11,150,000.00	25,650,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	8,766,666.44	9,558,333.07
39303	Бусад биет бус хөрөнгө		586,563,700.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>10,839,975,611.81</u></b>	<b><u>14,483,846,508.26</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>4,648,083.50</u></b>	<b>-</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	4,648,083.50	-
<b>413</b>	<b>Өглөг</b>	4,648,083.50	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг		
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	4,648,083.50	
41330	Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг		
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>10,835,327,528.31</u></b>	<b><u>14,483,846,508.26</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	10,835,327,528.31	14,483,846,508.26
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,204,052,310.16	1,790,616,010.16
51101	Өмч: - төрийн	1,204,052,310.16	1,790,616,010.16
51102	- хувийн		
51103	- хувьцаат		
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	8,566,544,037.35	7,720,589,877.20
51210	Өмнөх үеийн үр дүн	8,566,544,037.35	8,566,544,037.35
51220	Тайлант үеийн үр дүн		(845,954,160.15)
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс		
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,064,731,180.80	4,972,640,620.90
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга		
51600	Нөөцийн сан		
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>10,839,975,611.81</u></b>	<b><u>14,483,846,508.26</u></b>

## 4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,340,128,362.00</b>	<b>2,558,904,987.91</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	-	-
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>138,731,512.00</b>	<b>328,716,887.91</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	138,731,512.00	328,716,887.91
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	138,731,512.00	328,716,887.91
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,206,466.00	128,546,840.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,525,046.00	48,045,300.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих		
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		152,124,747.91
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,201,396,850.00</b>	<b>2,230,188,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,195,337,100.00	2,230,188,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,195,337,100.00	2,230,188,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,059,750.00	-
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,059,750.00	
131106	Төсвийн урамшуулал		
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,029,812,074.19</b>	<b>3,404,859,148.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,029,812,074.19</b>	<b>3,404,859,148.06</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,906,398,363.19	3,233,250,138.54
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,316,932,256.60	1,410,465,560.09
210101	Үндсэн цалин	963,072,343.56	1,410,465,560.09
210102	Нэмэгдэл	273,643,355.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	80,216,558.04	
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	170,777,047.00	161,504,560.70
210201	Тэтгэврийн даатгал	108,676,304.00	108,388,039.38
210202	Тэтгэмжийн даатгал	15,525,184.00	13,283,053.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,420,149.00	10,843,425.51
210204	Ажилгүйдлийн даатгал	3,105,035.00	2,632,112.31
210205	Эрүүл мэндийн даатгал	31,050,375.00	26,357,930.12
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	162,843,000.00	143,180,889.13
210301	Гэрэл, цахилгаан	67,191,370.00	55,551,418.00
210302	Түлш, халаалт	72,510,766.78	43,639,382.00
210303	Цэвэр, бохир ус	23,140,863.22	42,013,289.13

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210304	Байрны түрээс		1,976,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	76,896,287.85	111,783,771.97
210401	Бичиг хэрэг	28,966,651.23	1,346,420.00
210402	Тээвэр, шатахуун	3,400,000.00	4,130,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,831,229.93	11,185,208.63
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,971,170.00	4,756,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	26,584,253.33	90,366,143.34
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	142,983.36	
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	106,346,960.40	116,824,915.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,052,039.40	295,800.00
210502	Хоол, хүнс	100,842,521.00	110,464,855.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,452,400.00	6,064,260.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	18,955,411.00	14,561,000.00
210604	Урсгал засвар	18,955,411.00	14,561,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	2,493,170.00
210702	Дотоод албан томилолт		2,493,170.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	69,259,114.00	71,703,521.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,530,220.00	66,242,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,727,300.00	3,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	486,194.00	220,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	272,400.00	359,921.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	981,600.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	198,000.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	984,388,286.34	1,200,732,750.65
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,057,960.00	194,099.91
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	82,606,988.18	340,150,092.07
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	872,723,338.16	860,388,558.67
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	123,413,711.00	171,609,009.52
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	-	-
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	115,682,380.00	101,915,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	31,621,730.00	88,810,900.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	30,398,400.00	12,584,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	53,662,250.00	520,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,731,331.00	69,693,509.52
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,731,331.00	69,693,509.52
213304	Хөрөнгийн		
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(689,683,712.19)</b>	<b>(845,954,160.15)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(689,683,712.19)</b>	<b>(845,954,160.15)</b>



### 4.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,340,128,362.00</b>	<b>2,407,033,240.00</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	-	-
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	-	-
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	-	-
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>138,731,512.00</b>	<b>176,845,140.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	138,731,512.00	176,845,140.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	138,731,512.00	176,845,140.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	115,206,466.00	128,546,840.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	23,525,046.00	48,298,300.00
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих		
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,201,396,850.00</b>	<b>2,230,188,100.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,195,337,100.00	2,230,188,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,195,337,100.00	2,230,188,100.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	6,059,750.00	-
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	6,059,750.00	
131106	Төсвийн урамшуулал		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,330,135,362.00</b>	<b>2,341,400,240.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,330,135,362.00</b>	<b>2,341,400,240.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,198,527,901.00</b>	<b>2,169,791,230.48</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,440,917,073.00	1,316,671,287.96
210101	Үндсэн цалин	1,091,043,718.00	1,310,125,139.56
210102	Нэмэгдэл	273,643,355.00	
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,230,000.00	
210104	Урамшуулал		6,546,148.40
210105	Гэрээт ажлын хөлс		
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	170,777,047.00	251,312,274.79
210201	Тэтгэврийн даатгал	108,676,304.00	251,312,274.79
210202	Тэтгэмжийн даатгал	15,525,184.00	
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,420,149.00	
210204	Ажилгүйдлийн даатгал	3,105,035.00	
210205	Эрүүл мэндийн даатгал	31,050,375.00	
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	162,843,000.00	143,180,889.13
210301	Гэрэл, цахилгаан	67,191,370.00	55,551,418.00
210302	Түлш, халаалт	72,510,766.78	43,639,382.00
210303	Цэвэр, бохир ус	23,140,863.22	42,013,289.13
210304	Байрны түрээс		1,976,800.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	60,221,736.00	67,899,254.60
210401	Бичиг хэрэг	18,719,320.07	5,040,440.47
210402	Тээвэр, шатахуун	4,140,000.00	4,680,000.00

Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	13,318,790.93	16,119,492.13
210404	Ном, хэвлэл		
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	10,065,600.00	4,756,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,978,025.00	37,303,322.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал		
210408	Бараа материал акталсны зардал		
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	110,875,221.00	116,282,055.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	941,500.00	1,937,200.00
210502	Хоол, хүнс	100,842,521.00	110,464,855.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,091,200.00	3,880,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	22,235,087.00	31,005,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		2,295,000.00
210602	Тавилга		
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		
210604	Урсгал засвар	22,235,087.00	28,710,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	-	2,493,170.00
210701	Гадаад албан томилолт		
210702	Дотоод албан томилолт		2,493,170.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах		
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	69,530,587.00	71,557,321.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	63,530,220.00	66,242,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,727,300.00	3,900,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	486,194.00	220,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	433,300.00	359,921.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	75,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	835,400.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	288,573.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	161,128,150.00	169,389,178.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	485,070.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	160,643,080.00	169,389,178.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>131,607,461.00</b>	<b>171,609,009.52</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	123,776,130.00	101,915,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	50,577,730.00	88,810,900.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	30,398,400.00	12,584,600.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	42,800,000.00	520,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	7,731,331.00	69,693,509.52
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,731,331.00	69,693,509.52
213304	Хөрөнгийн		
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	100,000.00	-

213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	100,000.00	
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>9,993,000.00</u></b>	<b><u>65,633,000.00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>9,993,000.00</b>	<b>65,633,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>9,993,000.00</b>	<b>65,633,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	9,993,000.00	65,633,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	9,993,000.00	65,633,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>(9,993,000.00)</u></b>	<b><u>(65,633,000.00)</u></b>

#### 4.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,204,052,310.16	1,064,731,180.80	9,256,227,749.54		11,525,011,240.50
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,204,052,310.16</b>	<b>1,064,731,180.80</b>	<b>9,256,227,749.54</b>	-	11,525,011,240.50
C07	Тайлант үеийн үр дүн			(689,683,712.19)		(689,683,712.19)
C08	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,204,052,310.16</b>	<b>1,064,731,180.80</b>	<b>8,566,544,037.35</b>	-	10,835,327,528.31
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,204,052,310.16</b>	<b>1,064,731,180.80</b>	<b>8,566,544,037.35</b>	-	10,835,327,528.31
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,204,052,310.16</b>	<b>1,064,731,180.80</b>	<b>8,566,544,037.35</b>	-	10,835,327,528.31
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		3,907,909,440.10			3,907,909,440.10
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	586,563,700.00				586,563,700.00
D08	Тайлант үеийн үр дүн			(845,954,160.15)		(845,954,160.15)
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,790,616,010.16</b>	<b>4,972,640,620.90</b>	<b>7,720,589,877.20</b>	-	14,483,846,508.26

#### 4.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

/ төгрөгөөр /

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,298,188,100.00</b>	<b>2,270,150,447.23</b>	<b>28,037,652.77</b>	<b>98.8</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,298,188,100.00</b>	<b>2,270,150,447.23</b>	<b>28,037,652.77</b>	<b>98.8</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,196,952,600.00</b>	<b>2,168,754,947.23</b>	<b>28,197,652.77</b>	<b>98.7</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1,384,369,600.00</b>	<b>1,384,369,600.00</b>	-	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	1,044,277,500.00	1,044,277,500.00	-	<b>100.0</b>
210102	Нэмэгдэл	263,862,100.00	263,862,100.00	-	<b>100.0</b>
210103	Унаа хоолны хөнгөлөлт	76,230,000.00	76,230,000.00	-	<b>100.0</b>
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>166,124,300.00</b>	<b>171,481,139.92</b>	<b>(5,356,839.92)</b>	<b>103.2</b>
210201	Тэтгэврийн даатгал	110,749,700.00	116,106,539.92	(5,356,839.92)	104.8
210202	Тэтгэмжийн даатгал	13,843,700.00	13,843,700.00	-	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,074,900.00	11,074,900.00	-	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	2,768,700.00	2,768,700.00	-	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	27,687,300.00	27,687,300.00	-	100.0
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>175,180,600.00</b>	<b>141,258,089.13</b>	<b>33,922,510.87</b>	<b>80.6</b>
210301	Гэрэл, цахилгаан	82,191,300.00	55,551,418.00	26,639,882.00	67.6
210302	Түлш, халаалт	66,528,700.00	43,693,382.00	22,835,318.00	65.7
210303	Цэвэр, бохир ус	26,460,600.00	42,013,289.13	(15,552,689.13)	158.8
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>38,447,100.00</b>	<b>47,828,249.10</b>	<b>(9,381,149.10)</b>	<b>124.4</b>
210401	Бичиг хэрэг	10,986,200.00	5,040,440.47	5,945,759.53	45.9
210402	Тээвэр, шатахуун	3,750,000.00	4,130,000.00	(380,000.00)	110.1
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,509,400.00	11,185,208.63	(1,675,808.63)	117.6
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,351,500.00	4,756,000.00	(404,500.00)	109.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,850,000.00	22,716,600.00	(12,866,600.00)	230.6

<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>143,328,200.00</b>	<b>119,767,525.75</b>	<b>23,560,674.25</b>	<b>83.6</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	891,000.00	1,937,200.00	(1,046,200.00)	217.4
210502	Хоол, хүнс	137,511,000.00	113,950,325.75	23,560,674.25	82.9
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	4,926,200.00	3,880,000.00	1,046,200.00	78.8
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>68,686,500.00</b>	<b>66,136,960.08</b>	<b>2,549,539.92</b>	<b>96.3</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,860,000.00	4,860,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	63,826,500.00	61,276,960.08	2,549,539.92	96.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,524,500.00</b>	<b>2,493,170.00</b>	<b>31,330.00</b>	<b>98.8</b>
210702	Дотоод албан томилолт	2,524,500.00	2,493,170.00	31,330.00	98.8
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>65,859,700.00</b>	<b>64,607,321.00</b>	<b>1,252,379.00</b>	<b>98.1</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	59,292,000.00	59,292,000.00	-	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,900,000.00	3,900,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	990,000.00	220,000.00	770,000.00	22.2
210804	Тээврийн хэрэгслийн татвар	370,900.00	359,921.00	10,979.00	97.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	990,000.00	835,400.00	154,600.00	84.4
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>152,432,100.00</b>	<b>170,812,892.25</b>	<b>(18,380,792.25)</b>	<b>112.1</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	152,432,100.00	170,812,892.25	(18,380,792.25)	112.1
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>101,235,500.00</b>	<b>101,395,500.00</b>	<b>(160,000.00)</b>	<b>100.2</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>101,235,500.00</b>	<b>101,395,500.00</b>	<b>(160,000.00)</b>	<b>100.2</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	88,650,900.00	88,810,900.00	(160,000.00)	100.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	12,584,600.00	12,584,600.00	-	100.0
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,298,188,100.00</b>	<b>2,285,551,457.00</b>	<b>12,636,643.00</b>	<b>99.5</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,230,188,100.00</b>	<b>2,158,326,037.00</b>	<b>71,862,063.00</b>	<b>96.8</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,230,188,100.00	2,158,326,037.00	71,862,063.00	96.8
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ</b>				

	<b>БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>68,000,000.00</b>	<b>127,225,420.00</b>	<b>(59,225,420.00)</b>	<b>187.1</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	60,000,000.00	98,610,120.00	(38,610,120.00)	164.4
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	28,615,300.00	(20,615,300.00)	357.7
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1</b>	<b>1</b>	<b>-</b>	
610001	Төсвийн байгууллага	1	1	-	
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>141</b>	<b>141</b>	<b>-</b>	
620001	Удирдах ажилтан	4	4	-	
620002	Гүйцэтгэх ажилтан	99	99	-	
620003	Үйлчлэх ажилтан	38	38	-	
<b>632</b>	<b>МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ</b>	<b>1,800</b>	<b>1,760</b>	<b>40.00</b>	<b>97.8</b>
632001	Төрийн өмчит МСҮТ	1,800	1,760	40.00	97.8

#### 4.6 Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

<b>Огноо:</b>	<b>Аудитын нэр:</b>	<b>Монгол Солонгосын Политехник Коллежийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	<b>Аудитын код:</b>
2019.02.22			САГ-2019/179/СТА-ТШЗ
<b>Шалгагдсан байгууллагын нэр:</b>	<b>Монгол Солонгосын Политехник Коллеж</b>		<b>Мянган төгрөгөөр</b>

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
<b>А</b>	<b>3</b>	<b>4</b>	<b>5</b>	<b>9</b>	<b>10</b>
1	Тус коллежийн шатахууны зарцуулалтын тайлан тооцоог шалгаж үзэхэд 2018 онд нийт 4,100.0 мянган төгрөгийн шатахууны талонг жолоочийн тооцооны хуудас хөтлүүлээгүй, шаардах хуудсаар олгож, зардалд бүртгэсэн байна.	4,100.0	Зөвлөмж өгөх	МСПК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Х.Цэгмид П.Пүрэвдорж
2	Тус коллежийн 2018 онд батлагдсан төсвийг бүлгийн дүнгээр хянаж шалгахад хангамжийн бараа материалын зардлыг батлагдсан төсвөөс 12,866.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.	9,381.1	Зөвлөмж өгөх	МСПК-ийн захирал, ерөнхий нягтлан бодогч	Х.Цэгмид П.Пүрэвдорж
	<b>Дүн</b>	<b>13,481.1</b>			